



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/400

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Канад Улсын Лаурел сан хооронд 2015 оны 8 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”, Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлэг, Канад Улсын Лаурел сан хооронд 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 4 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081516

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 08 сарын 22-ны өдрийн
А/Үе дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хью Макферсон Парсонс Hugh Macpherson Parsons	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Канад Улсын Лаурел сан	ГЭ0002442	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2019.09.20-2019.10.25 /5 хоног/ 2019.09.26-10.08 /14 хоног/ Нийт 19 хоног
2.	Матэн Каяалакакат а Матэн Mathen	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг Өмнөговь	Канад Улсын Лаурел сан	ГЭ0002443	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2019.09.20-2019.10.25 /5 хоног/ 2019.09.26-10.08

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
	Кауулаккат на Mathen		аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв					/14 хоног/ Нийт 19 хоног
3.	Фрэнч Жастин Кристофер French Justin Christopher	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Канад Улсын Лаурел сан	ГЭ0002444	Нүдний мэс засал судлал	Эмчлэх	2019.09.20-2019.10.25 /5 хоног/ 2019.09.26-10.08 /14 хоног/ Нийт 19 хоног
4.	Ма Дебора Mah Deborah	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Канад Улсын Лаурел сан	ГС0000307	Сувилахуй судлал	Сувилах	2019.09.20-2019.10.25 /5 хоног/ 2019.09.26-10.08 /14 хоног/ Нийт 19 хоног